



САНЖИЙН БАТАА

Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын
гүйцэтгэх захиргааны дарга
1959-1962 он

Богд хан уулын аймгийн Дархан чин вангийн хошуу одоогийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт малчин ардын гэр бүлд 1915 онд төрсөн. 1924-1928 онд Богд хан уулын хошууны бага сургууль, 1928-1930 онд Улаанбаатар хотод дунд сургуульд суралцжээ.

1930-1936 онд Төв аймгийн Баяндэлгэр сумын хамтралын нягтлан бодох, сумын захиргааны нарийн бичгийн дарга, хоршооны худалдагч зэрэг ажил хийж байгаад 1936 онд цэргийн албанд татагдаж, 1937-1941 онд бага дарга, номын багш, бригадын эвлэлийн товчооны дарга, улс төрийн хэлтсийн дарга зэрэг албыг хашсан байна.

1941-1943 онд Хуягт бригадын комиссар, улс төрийн орлогч зэрэг ахлах тушаалын

ажил хийж байгаад 1943-1946 онд Москва хотод Лениний нэрэмжит Цэргийн улс төрийн академид суралцжээ.

1946-1950 онд Цэргийн улс төрийн газрын хэлтсийн даргын орлогчоор ажиллаж байгаад 1950-1952 онд Улс төрийн газрын даргаар, 1952-1956 онд Улсыг батлан хамгаалах яамны сайд, Цэрэг, нийгмийг аюулаас хамгаалах яамны нэгдүгээр орлогч сайд, Ардын цэргийн жанжнаар ажиллаж байв.

1956-1959 онд БНМАУ-аас ЗХУ, БНАГУ-д Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байгаад 1959 оноос Гадаад орнуудтай найрамдал соёлоор харилцах Монголын хорооны дарга, мөн оноос Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар 1962 он хүртэл ажилласан юм.

1962-1966 онд МАХН-ын Төв хорооны тасгийн дарга, Намын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргын туслах, 1966 оноос МАХН-ын Төв Хорооны захиргааны хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байв.

Тэрбээр МАХН-ын XII, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII Их хурлаас Төв хорооны гишүүнээр, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатаар таван удаа, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгч, орлогч даргаар сонгогдож байжээ.

С.Батаагийн ажлын үр бүтээлийг төр засаг өндөр үнэлж, Сүхбаатарын одон”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Байлдааны гавьяаны одон”-гоор хоёр удаа, “Алтан гадас” одон бусад медалиудаар шагнаж, хурандаа генерал цол олгосон бөгөөд ЗХУ-ын Октябрийн хувьсгалын одон болон зарим орны одон медалиудаар шагнагдаж байжээ.